



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 онь 06 сарын 26 өдөр

Дугаар А/364

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван наймдугаар хуралдааны 2023 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын санхүү албаны дарга, төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт төсвийн ил тод байдал, аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр ашиг сэдэвт сургалтыг 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулахтай холбогдуулан 2,437,900 (хоёр сая дөрвөн зуун гучин долоон мянга есөн зуу) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	тоо	Нийт
1	Үдийн цай	50хүн * 2 удаа	1,000,000
2	Үдийн хоол	50 хүн * 28,758	1,437,900
Нийт			2,437,900